



АЖИЛ ХӨДӨЛМӨРИЙН АДИСЛАЛ

Ахлагч Давид И. Соренсен

Далын Ерөнхийлөгчийн Зөвлөл

**Залуу Насанд Хүрэгчдэд Зориулсан СБС-ийн Галын Дэргэдэх Ярилцлага
2005 оны Гуравдугаар Сарын 6 • Бригам Янгийн Их Сургууль**

Би энэ үдэш бидэнтэй хамт байгаа санваарын бүх удирдагчид хийгээд тэдний эхнэрүүдэд талархалаа илэрхийлэхийг хүсч байна. Би ялангуяа Ах, Эгч Сесил О. Самуелсон нарыг энд байгаад талархаж байна. Миний хувьд олон жилийн турш Ахлагч Самуелсонтой Ариун Сүмийн Хэлтэст ажилласан нь агуу боломж байсан билээ. Би Бригам Янгийн Их Сургуулийн оюутнууд болон факультет ч бас Ерөнхийлөгч Самуелсон болон түүний эхнэрийн удирдлага дор байснаараа адислагдсан гэдэгт итгэдэг.

Энэ үдэш би Сүмийн залуу хүмүүс та нарт юу ярихыг хүсч байгаагаа бодож байхдаа та нарын ихэнх нь оюутан болохыг анзаарсан. Үнэн хэрэгтээ, хайрт залуу найз нар минь бид бүгдээрээ сайн мэдээний оюутнууд биш гэж үү?

Нэгдсэн Улсын Мөнгөн Сангийн Хэлтэст ажилладаг нэгэн эр байжээ. Түүний ажил нь хуурамч мөнгө орж ирсэн эсэхийг хянан үзэх байв. Тэр мөнгөн дэвсгэртийг цухас хараад л жинхэнэ, эсвэл хуурамч эсэхийг хэлж чадахаар ажлаа маш сайн мэддэг байв. Нэгэн үдэш их хэмжээний хуурамч мөнгө хэвлэдэг хүмүүсийг илрүүлсэн тухай хэвлэлийн бага хурал дээр нэгэн хэвлэлийн ажилтан түүнд ингэж хэлжээ: “Та мөнгөн дэвсгэртийг ийм хялбархан илрүүлэхийн тулд тэднийг хуурамч гэдгийг сурахын тулд маш их цаг зарцуулсан байх даа.”

Тэр дараах байдлаар хариулжээ, “Үгүй ээ, Би хуурамч мөнгөн дэвсгэртийн талаар огт суралцаагүй. Би цагаа жинхэнэ мөнгөн дэвсгэртийг сурахад зориулсан бөгөөд ингэснээр төгс биш байдлыг илүү хялбархан олж мэдсэн.”

Сайн мэдээнд ч мөн адил, ах эгч дүү нар минь. Бид энд Есүс Христийн сайн мэдээг заахаар байгаа. Бидэнд хуурамч байдлыг сурах хэрэг байхгүй, учир нь бидэнд үнэн байна. Та нар үнэн Сүмийг сураад, Сүнсний та нартай ажиллахыг зөвшөөрвөл та нар хариултыг хүлээн авах бөгөөд өөрсдийн тулгарах олон янзын нөхцөл байдлуудад хэрхэн хариулахаа мэдэх болно. Мормоны Номны тухай нэгэн залуухан номлогчийн хуваалцсан энэ санаа олон жилийн турш

надад үнэн гэдэг нь батлагдсаар байгаа билээ: Мормоны Ном бол сорилт биш—бид юм гэдгийг санаарай.

Энэ үдэш миний та нартай ярихыг хүсч байгаа зүйл маань бүхэл сайн мэдээний хамгийн чухал зарчмуудын нэг юм. Би ажлын сургаалыг ярих болно. Миний юу хэлсэн нь та нарыг одоо хийж байгаа буюу ирээдүйд хийж болох ажилд тань удирдахад тусална хэмээн найдаж байна.

Ахлах сургууль буюу коллежоо төгсөж байгаа, эсвэл өөр тохиолдолд ажилд орох гэж байгаа та нар дараах асуултуудыг өөрсдөөсөө асууж байж болох юм: “Миний ажлын цаг хэд байх бол? Надад нэмэлт орлого байх уу? Ямар баяруудаар би амрах вэ? Надад найз нөхдийнхөөрөө зочлох, эсвэл хоббигоо үргэлжлүүлэх хангалттай цаг байх уу? ”Үүн шиг асуултуудтай байсан ч ажлын цагуудынхаа оронд чөлөөт цагууд дээрээ анхаарлаа төвлөрүүлж байвал энэ нь та нарыг илүү том боломжуудаас холдуулдаг.

Бурханы Ажил

Ажил хөдөлмөр бол мөнхийн зарчим юм. Дэлхий дээрх бүх баялагуудтай, бүр илүү их үргэлжлүүлэн ажилласаар байгаа хэнийг та нар мэдэх вэ? Бидний Тэнгэрлэг Эцэг! Тэр ажилчин. Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ маань бидэнд ажил нь тэнгэрт ч, газарт ч чухал гэдгийг Өөрсдийн үлгэр дуурайл, сургаалаараа үзүүлсэн. Жехова тэнгэр болон газрыг бүтээхээр *ажилласан* билээ. Тэр уснуудыг нэг дор хуримтлуулж, хуурай газрыг ил гаргасан. Тэр нар, сар, оддыг бүтээсэн. Тэр далай доторх мөн газар дээрх бүх амьд биеийг бүтээжээ. Тэгээд Эцэг дэлхий дээр Адам Ева хоёрыг бүтээгээд бусад бүх бүтээлүүдэд санаа тавьж тэднийг захир гэв (Эхлэл 1:1–28-ыг үз).

Гэвч Тэдний ажил Бүтээлтээр дуусаагүй юм. Агуу Үнэт Сувдаас бид, “Үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний *ажил* мөн миний алдар суу бөлгөө” (Моисе 1:39, налуу нь нэмэгдсэн болно). Энэ нь мэдээж эр хүн, эмэгтэй хүн, хүүхэд бүрийг хамруулдаг. Өөрийн санаа тавьж

байдаг бүх зүйлсээсээ Тэнгэрлэг Эцэг маань—та болон миний бодгалийн—бүр бидний мөнхийн бодгалийн ашиг тусын төлөө хөдөлмөрлөхийг сонгосон.

Есүс “Миний Эцэг одоо болтол ажилласаар байна. Би Өөрөө ч ажиллаж байна” гэж хэлсэн (Иохан 5:17). Тэр бас “Намайг илгээгчийн ажлыг Би . . . хийх ёстой” гэсэн (Иохан 9:4).

Ажил Бол Адислал Юм

Надад мөн та нарт ч гүйцэтгэх ажил бий. Сатан бидэнд ажлыг маань хэрэггүй зүйл, эсвэл огт ажиллах хэрэггүй гэдгийг итгүүлэхээр биднийг уруу татдаг. Хоёуланд нь түүний буруу. Бидэнд ажиллах хэрэгцээ бий. Бид өөрсдийнхөө мөн гэр бүлүүдийнхээ хэрэгцээг хангаж байх үүрэг хариуцлагатай. Энэ биеэ даах уламжлал нь Адам Ева хоёрыг Едений цэцэрлэгийг орхисон цагаас Их Эзэний зам байсан. Их Эзэн Адамд “Духныхаа хөлсийг дуслуулан байж хоолоо олж иднэ” гэж хэлсэн билээ (Эхлэл 3:19). Адам Ева хоёр өөрсдийнхөө хэрэгцээ болон хүүхдүүдийнхээ хэрэгцээг хангаж болохын тулд талбайд ажилласан (Моше 5:1-ийг үз).

Өөрсдийнхөө хэрэгцээг хангах нь ажлын цорын ганц зорилго биш юм. Та нарт маш их хэмжээний мөнгө өгсөн, эсвэл ямар нэг арга замаар маш хурдан санхүүгийн хувьд биеэ даасан байна гэж төсөөлдөө. Тэгсэн ч ажиллах зарлиг хэвээр л байна. Их Эзэн Израилын хүмүүст “Зургаан өдөр чи хөдөлмөрлө” гэж хэлсэн байдаг (Египетээс гарсан нь 20:9). Тэр хангалттай байгаа хүмүүст зориулж ажиллах хэрэггүй байх ямар ч шалтгийг багтаагаагүй. Ахлагч Нил А.Максвелын дүрслэн хэлсэнчлэн, “Хэдийгээр зарим талаараа ажил хөдөлмөр нь сүнслэг хэрэгцээ байдаг ч ажил нь эдийн засгийн хэрэгцээ биш юм” (in Conference Report, 1998 оны 4 сар, 50; or *Ensign*, 1998 оны 5 сар, 38).

Ажил нь хараал зүхэл бус харин адислал; ажилласнаар бид Бурханы зарлигт дуулгавартай байгаад зогсохгүй бид өөрсдийгөө Бурханы аврах ивээлд оролцуулах болно. Их Эзэн хэлэхдээ “Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь” гэсэн (Иохан 14:15). Тиймээс хэрэв бид Түүнийг хайрлаж, Түүнтэй хамт байхыг хүсвэл Адамд өгсөн эртний зарлиг болох ажиллахыг багтаан Түүний зарлигуудыг дуулгавартай дагах ёстой гэдгийг Христ бидэнд тодорхой болгосон.

Их Эзэн Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд Сэргээлтийн эхэн үеэс “Эдүгээ, Сионы оршин суугчид Их Эзэн миний таалалд үл нийцнэ, учир нь та нарын дунд

залхуурагчид буй” гэж хэлжээ (С ба Г 68:31). Мөн хожим, 20-р зуунд Бурханы бошиглогч Ерөнхийлөгч Хибер Ж.Грант “Ажил хөдөлмөр бол манай Сүмийн гишүүнчлэлийн амьдралд гол удирдах зарчим болон дээш залрагдах ёстой” гэжээ (in Conference Report, 1936 оны 10 сар, х.3).

Хүмүүс хэрэв ажилладаггүй байсан бол юу болох байсан талаар та нар ер нь бодож үзсэн үү? Сургуулиуд маань үйл ажиллагаа явуулах байсан уу? Засгийн газар маань ажиллах уу? Телевизүүд маань хөтөлбөртэй байх байсан уу? Хэдийгээр бид заримдаа хүсч байсан бүх мөнгөтэй байгаад дахин ажиллахгүй байх юмсан гэж боддог ч энэ нь үнэн аз жаргалын зам биш гэдгийг би баталж байна. Миний уулзсан хамгийн ой гутам хүмүүсийн зарим нь ямар нэг шалтгаанаар удаан хугацааны турш ажиллаагүй хүмүүс байв.

Ажил нь гэр бүлийн үүрэг хариуцлага юм. Та нарын зарим нь гэрээсээ хол байгаа гэдгийг би мэднэ. Би та нарт яг одоо та нар гэр бүлийнхээ ажлаас ашиг тусыг авч байгаа гэдгийг тань сануулья. Эцэг эх тань та нарын биеийн, сүнсний мөн сэтгэл санааны сайн сайхныг хангахаар шаргуу хөдөлмөрлөсөн. Тэд өөр хэн ч өөрсдийнх нь энэ үүрэг хариуцлагыг авахыг хүлээж суугаагүй. Тэд *та нарыг* ачааных нь заримыг хуваалцахыг хүлээдэг.

Намайг хүүгийнхээ Харвардын Эдийн Засгийн Сургуулиас төгсөх ёслолд оролцож байхад сүмийн гишүүн Дин Ким Кларк өмсгөлөө өмсөөд урд эгнээнд суусан төгсөж байгаа оюутан бүрийг хайртай хүмүүс рүүгээ хойш харахыг хүсэв. Төгсөгчдийг эргэж харахад Дин Кларк түр зогсохийгээд ингэж хэлэв, “Гэр бүлийн гишүүдийн дэмжлэггүйгээр та нар өнөөдөр энэ хүндэтгэлийг хүлээж авахгүй байх байсан.” Та нарын хүн тус бүрт тийм байгаа. Та нар маш ихийг хүлээн авсан. Үүний хариуд та нараас мөн адил дэмжлэгийг хүүхдүүд мөн гэр бүлүүддээ үзүүлж, тэднийг хайрлахыг хүлээдэг, бүр шаарддаг. Энэ нь (өдрийн мөчлөгийг ашиглан) үргэлжлүүлэн “дүүжлэгдсээр бай” гэсэн үг биш. Та нарыг өсөж том болоход эцэг эх тань өөрсдийгөө хангаж, бие даахыг та нараас хүлээдэг.

Бид бүгд ажлаа хуваадаг. Гэр бүлийнхээ ажилд өөрсдийн хэсгийг хийх ёстойг хүүхдүүддээ заахыг эртнээс эхлэх нь чухал гэдгийг санаарай. Та нарын ажиллахыг заасан гэрт өссөн тэдгээр нь өнөөдөр амьдралд тань ямар үнэ цэнэтэй болох талаар гэрчлэлээ хуваалцаж чадна. Үүний жишээ болгон ердөө л өнгөрсөн Пүрэв гарагт Ахлагч Самуелсон надад түүнд ажиллахыг заасан аавтай байсандаа мөн

түүний эхнэрт нь ажиллахыг заасан эцэг эх хоёр байсанд хичнээн талархаж байгаагаа хэлсэн.

Бид чадах чинээгээрээ сүмийн гишүүдийн хувьд гэр бүлийнхээ амьдралын үндсэн хэрэгцээ болсон—хоол хүнс, хувцас хунар болон орох оромжийг—хамгийн сайнаараа хангах ёстой.

Дэлхийн зарим газруудад та нар гэр бүлийнхээ хэрэгцээг хангахаар хичээж байхдаа зовлон зүдгүүртэй тулгарах болно гэдгийг бид ойлгож байна. Эдгээр бэрхшээлүүдэд архаг хууч өвчин, хань ижлээ алдах, насан өндөр эцэг эхээ авчрах, эсвэл хүүхдүүдийнхээ боловсролыг тэтгэх нь багтана. Тэнгэрлэг Эцэг маань эдгээр нөхцлүүдэд байгаа гэр бүлүүдийг санаандаа байлгадаг. Энэ нь тэр та нарт давж гарах хүчийг өгнө гэдэг миний итгэл үнэмшил юм. Хэрэв бид Түүнээс итгэлтэйгээр асуувал тэр биднийг ямагт адислах болно.

Ажил Бол Үйлчлэл Юм

Сайн ажлын хандлагууд, зуршлууд мөн чадварууд нь амжилттай ажлын туршлагаар дамжин ирдэг. Тайлбарлахыг минь зөвшөөрнө үү. Миний өссөн мал аж ахуйн фермд үнээнүүдээ өдөр бүр үүр цайхаас өмнө саадаг байсан. Ням гараг буюу Зул Сарын Баяр, эсвэл аливаа бусад баяр байх нь огт хамаагүй. Үүнд хүйтэн байх нь хамаагүй. Хэн нэг нь ханиадтай байх нь хамаагүй. Үүнд нар шарж, цасаар шуурч байх нь ч хамаагүй. Өглөө бүр, үдэш бүр, нөгөө л хэвээр үнээгээ сааж байв.

Ах нар маань дайнд явахаасаа өмнө ихэнхдээ үнээ саадаг байв. Гэвч 1943 онд дөнгөж 10-тай байхдаа би пинд орж саалгуулахаар 10-12 үнээ хүлээж байдаг малынхаа саравчинд орсон билээ. Аав ээж хоёр минь чанга дуугаар үнээнүүддээ, “Өглөөний мэнд, та нарыг харахдаа таатай байлаа” гэдэгсэн. Үнэнээ хэлэхэд би залуу хөвгүүн байхдаа үнээнүүддээ ингэж ханддаггүй байлаа.

Үнээ бүрийг саасныхаа дараа би хувинтай сүүгээ 40 литрийн хувинд хийдэг байв. Тус бүр нь дүүрэхээрээ 36 кг болдог байлаа. Эдгээрийг би сүүний машиныг авахад зориулж тэднийг зам дээр аваачихаар балчирхан булчингуудаа ажиллуулах хэрэгтэй болдог байж билээ.

Намайг үнээ саахад аав маань аль болох тогтмол тусалж, ээж хааяа тусалдаг байв. Миний санаж байгаагаар аав ээж хоёр маань 80 хол гартлаа сүү саахаа үргэлжлүүлсэн юм. Гэвч аав минь хийх ёстой учраас үнээнүүдээ саадаггүй байсан юм, тэдэнд саалгах нь

хэрэгтэй учраас тэр саадаг байв. Үүнд ялгаа бий. Түүний хувьд эдгээр үнээнүүд нь зүгээр л нэг амьтад байгаагүй, харин тэд бол Том Хархан, Босси, Салли мөн Бетси байсан. Тэр тэднийг сэтгэл хангалуун байлгахыг хүсдэг байв. Тэр үнээнүүд сэтгэл хангалуун байхдаа их сайн сүү өгдөг гэж ямагт хэлдэг байсан. Аавд маань үнээ саах нь—ухаалаг бус мэт санагдаж байсан ч энэ нь луйвар бус харин боломж юм. Үнээ саах нь түүний хувьд ажил бус үйлчлэл билээ.

Энэ гүн ухаан нь намайг өсөхөд тусалсан ямар нэг зүйл билээ. Энэ нь намайг зөв шударга ажил бүхэн эрхэм гэдгийг ойлгоход минь тусалсан юм. Цөөн жилийн дотор, эдгээр гэрийн ажлыг гүйцэтгэх нь үнэн хэрэгтэй итгэл зориг, хүчний мэдрэмжийг надад өгч эхэлсэн. Би ажлаараа бахархах болсон. Би хэн ч намайг хийж байгаа ажлаараа доод тушаалтан гэж мэдрүүлж чадахгүй гэдгийг олж мэдсэн. Елинар Рузвельтийн хэлсэн шиг, “Та нарын зөвшөөрөлгүй хэн ч та нарыг доод тушаалтан гэж мэдрүүлж чадахгүй” (“Points to Ponder,” *Reader’s Digest*, 1963 оны 2 сар, 261). Та нар л өөрсдийн хандлагууд, ялангуяа залуу хүмүүс та нар ажлын талаарх хандлагуудаа хянана. Өөртөө итгэх болон бүрэн эрхэт байдал нь та нарт анги, нийгэм, ажил дээр тань сайн үйлчилж чадна.

Өдөр тутмынхаа ажлыг татвар гэж бодохынхоо оронд бид үүнийг боломж гэж бодох ёстой. Энэ нь л үнээнүүдийн тухай ямар сэтгэгдэлтэй байхыг заасан яг тэр эцгийн маань арга зам юм. Эдгээр сургаалууд нь бүхэл амьдралын маань туршид надтай үлдсэн бөгөөд би аль болох тогтмол мал аж ахуйн ферм дээрээ болон үүний тухай дурсамжууд дээрээ үргэлжлүүлэн айлчилсаар байх болно.

Үүний тухай бод. Хэрэв аав маань цөөн үнээнүүддээ зорилгыг олж чадсан бол бидний хүн тус бүр маань ажилдаа зорилгыг олж чадах нь мэдээж.

Ажлыг Хайрлаж Сур

Амьдралдаа сэтгэл хангалуун байх миний мэддэг хамгийн сайн аргуудын нэг нь ажлыг хайрлаж сурах юм. Миний эхнэр Верла төгс жишээ юм. Тэр 10 настайдаа өвчтэй нагац эгч Бертадаа аяга таваг угаах, гэр цэвэрлэх зэргээр ажиллаж эхэлжээ. Тэр одоо ч ажилласаар байгаа. Түүний хийж байсан ажлын төрлүүд нь амьдралынх нь үе бүхэнд өөр байсан. Тэр оюутан байхдаа толгой цохиж, цөөн хэдэн жил нэгдүгээр ангийнханд зааж, долоон хүүхдээ өсгөн хүмүүжүүлж, Эцэг Эхийн Холбоонд ажиллаж, орон нутгийн сургуулийн захиргаанд үйлчилж, номлолын талбарт хөдөлмөрлөж,

олон зуун Сүмийн яриануудыг өгч, олон нийтийн удирдах албанд үйлчилж мөн сайн дурын ажилтан байсан.

Түүний ажлуудын заримыг дэлхий жирийн л нэг гэрийн ажил гэж үздэг. Түүний ажлуудын зарим нь курсээ дүүргэх гэсэн оюун ухааны ажлууд байсан бөгөөд үүний ихэнх нь сайн мэдээг заахын сүнслэг чармайлт байв. Гэвч даалгавар нь ямар байхаас үл хамааран тэр ямагт бүх хүч чармайлтаа өгдөг байсан. Тэр ажилдаа агуу баяр баяслыг олдог байлаа. Тэр дөнгөж өнөөдөр надад хэзээ ч ажиллахад хэтэрхий хөгшин болчихгүй юмсан гэж найддагаа 90 гарсан хойноо хэлж байсан Вера Нагац шигээ болохыг хүсч байгаагаа хэлсэн билээ. Миний мэддэг хамгийн аз жаргалтай хүмүүс тэр нь юу ч байсан ажилдаа сэтгэл хангалуун тэдгээр нь байсан.

Та нар ажилд хэрхэн хандаж байгаа нь бүгдийг өөр өөр болгодгийг үзүүлсэн түүхийг санаж байж магадгүй юм.

Аянчин чулууны ил уурхайн дэргэдүүр өнгөрч яваад гурван хүн ажиллаж байхыг харжээ. Тэр хүн бүрээс юу хийж байгааг нь асуув. Хүн бүрийн хариулт нэгэн ижил ажилд өөр өөрөөр хандаж байгааг үзүүлжээ.

“Би чулуу хагалж байна” гэж эхний хүн хариулав.

Хоёр дахь нь “Би өдөрт гурван ширхэг алтан зоосыг хөлсөнд авч байна” гэв.

Гурав дахь нь инээгээд “Би Бурханы өргөөг барихад тусалж байна” гэв.

Эртний үгэнд “та нарын хандлага зөн билгийг тань тодорхойлдог” гэснийг санаж яваарай.

Бид энэ нь юу байхаас үл хамааран ажилдаа бүрэн хангалттай зорилгыг олж чаддаг байх ёстой. Аливаа шударга ажилд бид Бурханд үйлчилж чадна. Нифайн бошиглогч Бенжамин Хаан “Та нар бусдаа үйлчилж байх үед та нар зөвхөн өөрсдийн Бурханд үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тул буюу” гэж хэлсэн (Мозая 2:17). Хэдийгээр бидний ажил энгийнээр гэр бүлийн маань хэрэгцээг хангахад тусалдаг ч бид Бурханы хүүхдүүдэд тусалсан хэвээр байх болно.

Их Эзэн залхуу буюу хойрго хүмүүсийг таалдаггүй. Тэр “Мөн тэрээр наманчилж мөн өөрийн замуудыг өөрчлөхгүй бол залхуурагч сүмд байргүй байх болно” гэж хэлсэн (С ба Г 75:29). Тэр мөн “Чи залхуу байх ёсгүй, учир нь залхуу тэрээр хөдөлмөрлөгчийн талхыг ч идэх, мөн өмсгөлүүдийг ч өмсөх ёсгүй бөлгөө” гэж тушаасан (С ба Г 42:42).

Сүмийн бүр хамгийн эртний өдрүүдээс бошиглогчид маань Хожмын Үеийн Гэгээнтнүүдийг биеэ даасан, өөрийгөө аваад явчихдаг байхыг мөн залхаг байдлаас зайлсхийж байхыг заадаг байв. Жинхэнэ Хожмын Үеийн Гэгээнтнүүд өөрсдийн нуруун дээрх ачааг өөр хэн нэгэн дээр зориудаар шилжүүлдэггүй. Та нар залуу найз нар минь, одоо яг энд өөрийн нөхцөл байдлуудад чадахынхаа хирээр өөрийн хүчинд амьдралынхаа туршид итгэх болно гэдгээ шийд.

Та нарын олонх залуу эмэгтэйчүүд одоо ээж нар байгаа эсвэл болж хүүхдүүдээ өсгөхөөр олон жилийг гэртээ өнгөрүүлэхээр адислагдана. Бусад эгч та нар ээж болох боломжгүй юмуу хэрэв ээж болсон ч байнга гэртээ байх боломжгүй байна. Нөхцөл байдал тань ямар ч байсан залуу эмэгтэйчүүд та нарыг бүгдийг тань бошиглогчдийнхоо зөвлөгөөг дагаж чадах чинээгээрээ сайн боловсрол олж авахыг уриалж байна. Боловсрол нь өөрөө үнэ цэнэтэй юм. Боловсрол тань та нарыг гэртээ хүүхдүүдээ өсгөн байхад хамгаалагдсан гэдэг сэтгэгдлийг өгөх болно. Хэрэв ирээдүй тань та нарыг цалинтай ажиллах хүч рүү хөтөлвөл ерөнхийд нь хэлэхэд, боловсрол нь таныг илүү ач холбогдолтой, бүтээлтэй ажил эрхлэлтийг таньд зөвшөөрнө.

Ажил хөдөлмөр маань өөрөө шулуун шударга бөгөөд зохистой зорилгуудын тулд байдаг. Биднийг муу ёрын буюу залхаг байдлаас хөрөнгөтэй болоход Тэнгэрлэг Эцэг маань дуртай байдаггүй. Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл үүнийг дараах аргаар үзүүлсэн: “Би цэвэр [ариун] цаг, хүч чадал, үнэнч байх болон үйлчлэл үзүүлээгүй байж цалин хөлс авдаг [тэдгээр] хүмүүс бохир мөнгө авч байна гэж үнэндээ боддог” (Conference Report, 1953 оны Аравдугаар сар, 52). Хүчтэй үгс биш гэж үү? Тэр бас хэлэхдээ хулгай, потерей зэрэг мөрийтэй тоглоом, буруу замаар олсон бохир мөнгө, хууль бус эм тариа зарах, ядуусыг дарлах зэрэг чөтгөрийн буюу залхуу байдлын туршлагаас олдсон мөнгө цэвэр бус гэжээ.

Ерөнхийлөгч Кимбалл эрхэм ажил, муу ёрын ажил хоёрын хоорондох ялгааг тодорхойлсон:

“Цэвэр мөнгө гэдэг бол шударга ажлын бүтэн өдрөөс ирдэг нөхөн төлөөс юм. Энэ нь итгэлтэй үйлчлэлийн ухаалаг төлбөр, бараа, өргөн хэрэглээний зүйл эсвэл ахуй үйлчилгээний хямдралаас өссөн цэвэр ашиг, бүх талуудад ашигтай байх хэлэлцээнээс ирсэн орлого юм.

“Бохир орлого бол, хулгай, дээрэм . . . мөрийтэй тоглоом . . . нүгэлтэй үйл ажиллагаа . . . хахууль

өгөх мөн . . . мөлжлөгөөр олсон мөнгө юм” гэжээ (Conference Report, 1953 оны Аравдугаар сар, 52).

Хурдан баяжин амар хялбар амьдрал амлаж хялбар мөнгө олох хавх санал болгож байгаа олон хүмүүс өнөөдөр байна. Бид тэдний тухай байнга сонсдог. Эдгээр саналууд нь хуурамч зүйл бөгөөд бошиглогчид “хялбар мөнгөний” уруу таталтын золиос болохын эсрэг байхыг байн байн зөвлөдөг. Бид ухаалаг шүүлт хийх, эрсдэл болон ашиг тусын хооронд жинлэх, амьдралын илүү агуу учир холбогдлыг ойлгох чадвараа алдах ёсгүй.

Өдөр тутмын ажлын өдрүүдийн ертөнцөд тэдгээрийн олон нь махан биеийн бодол санаатай учир сүнслэг мэдрэлгүй байдаг. Тэдгээрээс зайлсхийхийг хичээ. Ажил эрхлэлтээсээ болоод сүнслэг байдлыг устгах тэдгээр хүмүүстэй холбоотой байх болох нь ямар эмгэнэлтэй вэ. “Учир нь хүн бүх дэлхийг олж авсан ч амиа алдвал ямар ашиг байх билээ?” (Марк 8:36). Их Эзэн бидэнд “төрөлх хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй. Учир нь тийм хүнд эдгээр нь мунхаг явдал бөгөөд эдгээрийг ойлгож чадахгүй. Яагаад гэвэл эдгээр нь сүнслэгээр үзэгддэг” гэж хэлсэн (1 Коринт 2:14).

Ер нь бид ажил, амралт хийгээд зугаа цэнгэлийн хооронд зохих тэнцвэрийг олох ёстой. Ажилгүйгээр амралт, зугаа цэнгэлийн утга алдагдана. Эртний үгэнд “юу ч хийхгүй байх нь бүгдээс хэцүү ажил юм” гэсэн байдаг нь таатай хийгээд хэрэгтэй байгаад зогсохгүй бидэнд Хүндэтгэлийн өдөр амрахыг зарлигладаг (Египетээс гарсан нь 20:10-ыг үз). Их Эзэн хүндэтгэлийн өдрийг сахисан тэдгээр хүмүүст “бүхэл дэлхий та нарынх” гэж амладаг (С ба Г 59:16).

Та нарын зарим нь Соренсен эгч бид хоёрыг хэдэн жил Азид байсан гэдгийг мэднэ. Тэнд амьдарч байхдаа бид “Дуртай мэргэжлээ сонго, тэгвэл чи амьдралдаа нэг ч өдөр ажиллахгүй болно” гэсэн эртний зүйр үгсийг сонсдог байсан. Би ихэнх хэсэгт энэ нь хүсүүштэй бодол гэж итгэдэг. Би баргар дүнсгэр зүйл хэлэхийг хүсэхгүй байна. Гэвч бодит байдалд ажил нь ямагт угаасаа сэтгэл татахаар зүйл биш юм. Үүний нилээд тохиромжтой нь Ерөнхийлөгч Томас С.Монсоны зөвлөгөө гэж би боддог. Тэр “Хайраа сонгоод, сонголтоо хайрла” гэсэн (Conference Report, 1988 оны Аравдугаар сар, 82; эсвэл *Ensign*, 1988 оны Аравнэгдүгээр сар, 71). Тэр үүн дээр үнэн хэрэгтээ гэрлэлтийн тухай ярьж байгаа ч би энэ зөвлөгөөг та нарын ажил мэргэжлээ сонгоход аль болох тохирох болгоё. Өөрийн дуртай ажлаа сонго, тэгээд сонголтоо хайрла.

Би юу гэх гээд байна гэвэл олон хүмүүс ажлаа илүү сонирхууштай дур булаам эсвэл дор хаяж уйтгартай биш байх ёстой гэсэн загварт баригддаг! Амьдрал хэцүү болоод ирэхэд—энэ нь тойрох аргагүй юм—тэд сонгосон ажлаа өөрсдийнх нь бодож байсан шиг биш байж магадгүй хэмээн бодож эхэлдэг. Тэд хажуу хашааныхаа өвсийг илүү ногоон гэдэгт итгэж эхэлдэг. “Би хуулийн оронд анагаахыг судлахаар шийдсэн бол сайн эмч болж болох байсан” гэх хошин үг шиг болно. Эсвэл магадгүй “би түүнийх шиг чухал хүчирхэг ажилтай байхыг хүсч байна. Хэрэв би түүн шиг босс байсан бол маш хичээнгүй ажиллаж, хүмүүст сайн хандаж, амжилттай байх болно” гэж болох юм.

Энэ загвараас зугтаж чаддаггүй хүмүүс *аливаа* мэргэжилд амжилтанд хүрэхдээ ихэнхдээ бэрхшээлтэй тулгардаг. Тэд ажил мэргэжилдээ дурласан ч удалгүй жижиг болоод энгийн зүйлүүдэд сэтгэл нь татагдахаа больж тэднийг хөтлөх уран зөгнөлөө хөөхийн тулд ажлаа орхидог. Тэд нэг ажлаас нөгөө рүү нисэн дүүлж жинхэнэ амжилтанд хүрэх хангалттай удаан нэг дороо тогтож чаддаггүй. (Хэрэв миний дүгнэлт хэн нэгний тань санааг зовоосон бол, тэднийг наманчлахыг урьж байна.)

Чи ажлаа нэгэнт сонгосон бол үүнийгээ хайрла. Ямар ч ажил төгс биш. Бүхий л ажил мэргэжил өөрсдийн гэсэн сорилтууд, хүнд хэцүү өдрүүдтэй. Ажлын амжилт бүтээл нь гэрлэлттэй адил олон жилийн онцгой *адислал*, *цөхрөлтгүй чармайлт* шаарддаг.

Би та нарт жишээ өгье. Чадварлаг зураач барималч Микеланжела өөрийн ажлын тухай гүн гүнзгий үзэл бодлоо хуваалцсан. Тэр хэлэхдээ, “Хэрэв хүмүүс намайг энэ чадвараа эзэмшихийн тулд хир шаргуу ажилласныг мэдвэл тэдэнд тийм гайхамшигтай санагдахгүй байсан” гэжээ. Олонх тань Микеланжеллагийн ховор бүтээлүүдийг харсан байх. Гэхдээ бидний хичнээн нь нэг бүхэл гантиган хавтангаар хийгдсэн Давидын барималыг хийх ажил нь урагшгүй, залхуутай байсан тухай бодохоор зогссон бол! Тэгээд 14 фут өндөртэй Давидын хөшөөг босгосон! Үнэн хэрэгтээ Давид бол Микеланжеллагийн анхны баримал биш юм. Энэ шилдэг бүтээлээс өмнө тэр олон удаа зуун мөн мянган барималуудыг хийхээр тэмцэж хөдөлмөрсөнд эргэлзэх зүйлгүй. Хэрэв Микеланжела эхний хэдэн жилдээ гантигаар баримал хийх биеийн хүч шаардсан ажил нь хэтэрхий хүнд, залхуутай, уйтгартай гээд зохиолч болохоор шийдсэн бол ямар эмгэнэлтэй хэрэг болох вэ? Егөөдвөл хэрэв тэр энэ өөрчлөлтийг

хийсэн бол тэр зохиолч байх нь бас л залхуутай, уйтгартай юм гэдгийг олж илрүүлэх байсан.

Хэрэв та нар ажлынхаа доголдолтой талуудыг мөн өдөр тутмын жижиг болоод энгийн зүйлүүдийг үл харгалзан ажилдаа урам зоригтойгоор зүтгэвэл илүү амжилтанд хүрнэ. Өөртөө байгаа мэргэжил дээр анхаарлаа төвлөрүүлж илүү сайныг эрэлхийлүүлсэн уруу таталтын эсрэг зогс. Үнэндээ би та нар ямар ажил сонгосноос нэг их хамаарахгүй гэдгийг баттай хэлж байна. Хэрэв та нар ямагт нэг ажил дээрээ байж, сонгосон мэргэжилдээ амжилт гаргахыг эрэлхийлвэл маш их амжилттай байж мөн өөрсдийн төсөөлж чадахаас ч илүү *ажилдаа хайртай болж дуусдаг*.

Зөвлөх Үгс

Би хэдэн нэмэлт зөвлөмжүүдийг нэмье.

Нэгдүгээрт, бусадтай зэрэгцэн шаргуу хөдөлмөрлө. Бэрхшээлүүдийн нэг хэсэг байлгүй, харин шийдвэрийн нэг хэсэг бай. Үнэндээ шүүгч нь биш харин гэрэл нь болж байгаарай. Судалгаанууд нь хүмүүст техникийн мэдлэг буюу чадвар дутсанаас тэд ерөнхийдөө ажлаа алддаггүй гэдгийг дахин дахин баталж байна. Ихэнхдээ бэрхшээлүүд нь бусад хүмүүстэй нэгдмэл байж чадаагүйгээс болдог. Би та нарыг цаг үргэлж бүх хүмүүсийг таалж чадахгүй, харин ялангуяа эдгээр хүмүүсийн нэг таны босс бол ихэнх хүмүүсийг ихэнхдээ таалж чадна гэдгийг ойлгодог.

Хоёрдугаарт, Зөвхөн өөрсдийгөө хэмжих хэмжүүрээр хүмүүс өсөх нь ховор юм. Бусдын магтаалаас илүү тэдний шүүмжлэлийн үр дүнд би хувийн болон бизнесийн амьдралдаа илүү их дэвшилт гаргасан гэдгээ баттай хэлэх байна. Хааяа өөр хэн нэгний хэмжүүрээр өөрийгөө хэмжиж сур. Захирал чинь чамайг хэт амархан уурладаг гэж хэлсэн бол үүнийг бодож үз. Хэрэв гэр бүлийн хүн чинь чамайг хэт амархан уурладаг гээд мөн найзууд чинь ч бас чамайг хэт амархан уурладаг гэвэл, энэ нь чи хэт амархан уурладаг л гэсэн үг. Иймэрхүү дүгнэлтийг сонсохдоо үгүйсгэхээсээ өмнө сонс. Дүгнэлт хий. Цэгнэж үз. Өөрчлөлт дэс дараатай гэж бодно уу? Шүүмжлэлийг эс тооцон бусадтай таарамжтай байхыг сур. Чи өөрөө л хүсэх юм бол бусадтай таарамжтай байж чадна.

Гуравт өөдрөг бай. Гутрангуй байдлыг бүү хүлээн ав, ялангуяа энэ нь тань руу өөр лүү чинь чиглэсэн бол. Тэнгэрлэг Эцэгийн талаарх гутрангуй тунхаглалыг бүү хүлээн ав. Тэдний эх сурвалжийг бодолц—эдгээр нь Сатанаас ирж буй юм. Энэ Сүм эсвэл Сүмийн зааварчилгааны талаарх гутрангуй тунхаглалыг та бүү

хүлээн ав. Энэхүү үйл хэрэг болох аз жаргалд хөтлөх үйл нь Сатанаас ирэх захиасыг эсэргүүцэнэ.

Буцаж ирсэн номлогчдод хэлэх үг минь бол чиний номлолын талбараас суралцсан тэрхүү агуу туршлага, дадал, зарчмуудаа бүү орхиосой. Өөрийнхөө харагдах байдлыг бүү орхиосой. Ах нар та нарыг одоо энд гэртээ цагаан цамц өмсөж, зангиа зүүж, мөн бараан өнгийн костюм өмсөөсэй гэж хүлээж байгаа биш, харин ч номлолын талбартаа сурсан сайн хувцаслалтаа хадгалаасай гэдэг. Амжилтын төлөө хувцасла! Таны хувийн дадал чинь цэвэр байдал, намба, мөн залуу номлогч байхдаа таны зааж байсан сайн мэдэний зарчимд нөлөөлж та нарын ажиллаж байгаа газарт хүртэл үйлчлэх болно.

Дүгнэлт

Өнөө оройны миний захиас нь хоёр тунхаглалд нэгдэх болно. Эхнийхийг нь Ерөнхийлөгч Давид О.МакКей хэлсэн юм. Тэрээр хэлэхдээ, “Бид ажиллах боломж бол бэлэг, ажиллах хүч бол адислал, ажиллах хайр бол амжилт гэдгийг таних хэрэгтэй” гэжээ (*Pathways to Happiness*, [1957], 381).

Хоёр дахь нь бидний одоогийн ихэд хайрладаг амьд бошиглогч, Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлсэн юм. Тэрээр хэлэхдээ “Дэлхийн ихэнх ажлууд нь зөвхөн ухаантнуудаар хийгддэггүй. Энэ нь өөрсдийнхөө амьдралыг тэнцвэржүүлсэн, ердийн бус байдлаар ажиллаж сурсан жирийн хүмүүсээр хийгдсэн юм” гэсэн билээ (“Our Fading Civility,” Brigham Young University inauguration and spring commencement exercises, 1996 оны Дөрөвдүгээр сарын 25, 15). Бидний замд сэтгэл гонсойлт мөн тээнэгэлзэх явдал тохиолдох болно гэдэг нь өгөгдсөн, ах эгч нар минь.

Орсон Ф.Витни биднийг тайтгаруулахдаа:

“Бидний зовох зовлон гэж үгүй, бидний нүүр тулах саад гэж үгүй. Энэ нь бидний боловсролд номлон тэвчээр, итгэл, хатуужил мөн даруу байдал шиг, шинж чанарын хөгжил юм. Бидний зовсон бүхнийг мөн бидний тэвчсэн бүхнийг, ялангуяа үүнийг бид тэвчээртэйгээр гүйцэтгэвэл бидний зан чанарыг бэхжүүлэн, бидний зүрх сэтгэлийг ариусган, бидний сүнсийг хөгжүүлэн, биднийг илүү өрөвчхөн мөн нигүүлсэнгүй болгон Бурханы хүүхдүүд гэж дуудагдахад илүү зохистой болгоно. . . . Энэ нь бидний уучлал мөн тэвчээр нөр хөдөлмөр мөн зовлон зүдгүүрээр биелэгдэн тэнд бид боловсролыг олно, тэнд бид очоод таньдаг болно, мөн бидний тэнгэрт буй Эцэг мөн Эхтэй адил болгоно (Спенсер В.Кимбалл, *Faith Precedes the Miracle* - иш татав, [1972], 98).

Их Эзэний даруухан үйлчлэгчийн хувьд би та нарт амлаж мөн Түүний бошиглогч мөн судраар дамжуулан Их Эзэний жишгийг ажил хэрэгтээ хадгалан сурч, залбирч, мөн төлснөөр ажил хэргээсээ олсон өөрийнхөө мөнгөнөөс аравны нэг мөн мацгийн өргөлөө төлбөл, таны бүх амьдрал болон таны өдөр тутмын ажил хэрэг тань амжилттай байж болохыг адисалж байна. Та илүү сайн ажилчин байх болно. Та илүү бүтээлч ажилчин байх болно. Та илүү идэвхтэй ажилчин байх болно. Яагаад гэвэл энэ бүхэнд Их Эзэний Сүнс таньтай хамт байж мөн таныг зоригжуулах болно.

Би та нарт бидний хайрт бошиглогч Ерөнхийлөгч Хинклигийн онцгой мэндчилгээг хүргэмээр байна. Хэсэг хугацааны өмнө, Ерөнхийлөгч Хинкли өөрийнхөө гэр нь байдаг гадасныхаа гишүүдэд хэлсэн яриандаа “Ямар нэг зүйл нь бидний заримдаа боддог шиг тийм муу биш юм. . . . Би энэхүү Сүмийн талаар их өөдрөг бодолтой билээ. Энэ Сүмийн залуучуудийн талаар асар их өөдрөг үзэлтэй. Бид айх хэрэггүй юм. Хэрэв бид сайн мэдээний дагуу амьдардаг бол, хэрэв бид сайн мэдээний гэрэлд өөрсдийн шийдвэрийг гаргадаг бол бидэнд айх хэрэг байхгүй билээ. Хэрэв бид өвдөг сөхрөн Их Эзэнд Түүний гэгээрэл, ойлголт, чиглэл мөн зоригийн төлөө залбирдаг бол бидэнд айх зүйл үгүй бөгөөд бид айх хэрэггүй юм” гэжээ.

Тиймээс хүндэт залуу найз нар минь, би өнөөдрийн энэ үдэш та нарт өөрийн гэрчлэлийг үлдээмээр байна. Би энэ Сүмд итгэдэг. Би Есүс Христэд итгэдэг. Би Түүний хэлсэн зүйлст итгэдэг. Би Түүнийг Нифайчуудад ярьж байхдаа “Би тэнгэр мөн газрыг, мөн тэдний дээр буй бүх зүйлийг бүтээсэн билээ. Би эхлэлээс Эцэгтэй хамт байсан” (3 Нифай 9:15) хэмээн хэлсэнд итгэдэг. Би Түүнийг Адам Ева хоёрыг бүтээсэн

Елохим Эцэгийн Хүү гэдгийг мэднэ. Би хүндэт залуу найз нар минь, Хүүг Иудейгийн Бетлехемд Маригаас төрсөн гэдгийг мэднэ. Түүний төрөлт Матайгийн хэлсэн шиг Херод Хааны үед байсан гэдгийг мэднэ. Есүс Христ “Би бол ертөнцийн гэрэл мөн. Намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй болно гэж айлдав” гэсэн (Иохан 8:12). Би Есүс Христийн “Миний үгийг сахьдаг хүн үхлийг хэзээ ч үзэхгүй” гэж хэлсэнд итгэдэг (Иохан 8:51). Би Түүнийг болон Түүний Эцэгийг бошиглогч хүү Иосеф Смитэд үзэгдсэн гэдгийг мэднэ.

Хэрэв бид Есүс Христийн ажилд туслах юм бол Тэр бидний хүн тус бүрийн маань ажилд тусална гэдгийг би мэднэ. “Учир нь зөв шударгыг үйлдэгчдийн нэрс амьдралын номонд бичигдэх болно, мөн би тэдэнд өөрийн баруун гар дахь өвийг хайрлах болно. Мөн эдүгээ, ах дүүс минь, үүний эсрэг хэлэх юу та нарт буй билээ? Би та нарт хэлнэ, хэрэв та нар үүний эсрэг ярих аваас, тэр нь хамаагүй, учир нь Бурханы үг гүйцэлдэх ёстой” (Алма 5:58). Хэрэв бид түүний үгийг анхааралтай сонсвол бидний ажилд тусалж чадах амьд бошиглогч Гордон Б.Хинкли бидэнд байгаа гэдгийг би мэддэг бөгөөд гэрчилж байна.

Та нар хүндэт залуу найз нар минь, энэ Сүмийн итгэл найдвар. Та нар амьдарч байгаа газрынхаа ард түмний итгэл найдвар юм. Та нар энэ Сүмийн, мөн дэлхийн ирээдүйн удирдагчид билээ. Хэрэв та нар бидний Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүү Есүс Христийн төлөө ажиллах юм бол Тэр та нарыг амьдралын тань бүх өдрүүдэд адисалж, харж, хамгаалж байх болно гэсэн даруу гэрчлэлээ авчиръя. Би Түүний, бүр бидний Их Эзэн, Гэтэлгэгч, Аврагч, Израилын Ариун Нэгэн болох Есүс Христийн ариун нэр дээр энэ даруу гэрчлэлээ үлдээлээ.